



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 08 өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлтийг бүртгэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,500,000,000.00 /нэг тэрбум таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасан өөрчлөлтийг бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Монгол даатгал” ХХК /Ч.Энх-Амгалан/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны .5. дугаар сарын 08-ны өдрийн
21 дугаар тогтоолын хавсралт

“МОНГОЛ ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	“Миллениум секюритис менежмент лимитед” компани	35,396,690	3,539,669,005.07	100%	15,000,000	1,500,000,000.00		50,396,690	5,039,669,005.07	100%
	Нийт	35,396,690	3,539,669,005.07	100%	15,000,000	1,500,000,000.00		50,396,690	5,039,669,005.07	100%